



**ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК**

**АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ**

Тендер  
шалгаруулалтын  
нэр:

“ПТ-25-90/10М ТУРБИНГЕНЕРАТОР  
№7 ЦИЛИНДР СОЛИХ” АЖИЛ

Тендер  
шалгаруулалтын  
дугаар:

ДЦС3/20240101019

## I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

### А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

#### 1. Тендерийн цар хүрээ

1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу Өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон ажил, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “ажил” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг Өгөгдлийн хүснэгтэд заана.

1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг Өгөгдлийн хүснэгтэд заана.

1.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай Өгөгдлийн хүснэгтэд заана.

#### 2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг

2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг Өгөгдлийн хүснэгтэд тусгана.

#### 3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж

3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

#### 4. Худалдан авах ажиллагааны цахим систем

4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.

#### 5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20<sup>1</sup>, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.

#### 6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага

6.1. Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.

6.2. Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.

6.3.Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.

6.4.Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.

6.5.Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

6.6.Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7.Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

## **7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага**

7.1.Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

7.2.Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3.Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4.ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.

7.5.Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

## **Б. АГУУЛГА**

## **8. Тендер шалгаруулалтын баримт бичиг**

8.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2.Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

8.3.Сонирхогч этгээд ТШЗ, Өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер

бэлтгэнэ.

## **9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах**

9.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.

9.2. Тодруулга авах хүсэлтийг Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.

9.3. Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

9.4. Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.

9.5. Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө.

## **10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**

10.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.

10.3. ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.

## **11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах**

11.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

11.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

11.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.

## **В. ТЕНДЕР БЭЛТГЭХ**

## **12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл**

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.



12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

### **13. Тендерийн иж бүрдэл**

13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн ажил гүйцэтгэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1. ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3. ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4. оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.6. санал болгож буй ажил ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.7. ТШЗ-ны 21-д заасан ажлын төсөв;

13.2.8. ТШЗ-ны 21.7-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.9. Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

### **14. Тендерийн жишиг маягтууд**

14.1. Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

### **15. Хувилбарт санал**

15.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг

тендерийн хамт ирүүлж болно.

## **16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг**

16.1. Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадална. Үүнд:

16.1.1. ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.

16.1.2. Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн Өгөгдлийн хүснэгтэд заана.

16.2. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.2.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

16.3. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

16.4. Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.

## **17. Чадавхын болон туршлагын шаардлага**

17.1. Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.

17.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.

17.3. Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.

17.4. Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

17.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

## **18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох**

18.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага

## **баримт**

хангасан байна.

18.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.

18.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

18.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

## **19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**

19.1. Хуулийн 17.4-т зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.

19.2. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.

19.3. Ажил гүйцэтгэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

19.4. ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

## **20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг**

20.1. Санал болгож буй ажил нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.

20.2. III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.

20.3. Ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

## **21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт**

21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

21.2. Тендерт ирүүлэх өртгийн төсвийг холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан норм, нормативыг үндэслэн нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг эрх

бүхий этгээдээр баталгаажуулж ирүүлнэ.

21.3.Тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

21.4.ТШЗ-ны 21.2-т заасан төсвийн нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч V бүлгийн маягт 1-д заасан үнээс зөрүүтэй бол төсвийн нийт нийлбэрийг санал болгосон үнэ гэж үзнэ.

21.5.ТШЗ 21.1-т заасны дагуу үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг “тендерийн үнэ” гэж үзнэ.

21.6.Хууль болон Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

21.7.Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь ажлын хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

## **22. Тендерийн валют**

22.1.Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

## **23. Тендер хүчинтэй байх хугацаа**

23.1.Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.

23.1.Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.

23.2.Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.3.Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

## **24. Тендерийн баталгаа**

24.1.Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах

ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам"-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг Өгөгдлийн хүснэгтэд заана.

24.2.Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.

24.3.Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

## **Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ**

### **25. Тендер баталгаажуулах, илгээх**

25.1.Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2.ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3.Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4.Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн маягт **Error! Reference source not found.**7-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5.Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг Өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

### **26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**

26.1.Тендер хүлээн авах эцсийн хугацааг Өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2.Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр Өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

## **Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ**

### **27. Тендерийн талаар тодруулга авах**

27.1.Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

### **28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх**

28.1.Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар

авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ.

- 29. Тендерийг үнэлэх**
- 29.1. Хуулийн 11.4-т зааснаар захиалагч үнэлгээний үндсэн шалгуурыг сонгох бөгөөд өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол үнэлгээний үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.
- 29.2. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.
- 29.3. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.
- 30. Арифметик алдааг залруулах**
- 30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.
- 30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.
- 31. Давуу эрх олгох**
- 31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн бол хуулийн 8.4, 8.7-т зааснаар үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.
- 31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.
- 31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.
- 32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт**
- 32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
- 33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох**
- 33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална.
- 33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ.
- 33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
- 34. Тендерийг эрэмбэлэх**
- 34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5-д заасныг баримтална.
- 35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах**
- 35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног

төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан эсэхийг дахин магадална.

35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19 дүгээр зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.

35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

## **Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ**

**36. Шийдвэр хүргүүлэх** 36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.

**37. Гүйцэтгэлийн баталгаа** 37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.

37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.

**38. Урьдчилгаа төлбөр** 38.1. Гэрээг хэрэгжүүлэхэд шаардагдах бараа материал худалдаж авах болон ажил эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгох шаардлагатай бол захиалагч урьдчилгаа төлбөр олгох хувийг Өгөгдлийн хүснэгтэд заана.

38.2. Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөр авах хүсэлтийг уг төлбөрийн дагуу санхүүжүүлэх ажлын нэр төрөл, тоо хэмжээ, төсөв, ажил гүйцэтгэх хуваарийн хамт ТШЗ-ны 38.1-д заасан үнийн дүнгээс багагүй хэмжээний мөнгөн дүнтэй урьдчилгаа төлбөрийн баталгааг холбогдох этгээдээр гаргуулан захиалагчид ирүүлнэ.

38.3. Урьдчилгаа төлбөрийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.

38.4. Захиалагчийн хүлээн авсан, шаардлага хангасан урьдчилгаа төлбөрийн баталгаа нь гэрээний салшгүй хэсэг байна.

**39. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах** 39.1. Захиалагч ТШЗ-ны 8.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.

39.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 39.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

## II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: “Дулааны Гуравдугаар Цахилгаан Станц” ТӨХК
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: “ПТ-25-90/10М турбингенератор №7 цилиндр солих” ажил
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: <b>ДЦСЗ/20240101019</b>
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>“Багцгүй”</b>
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: <b>“Үгүй”</b>
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <b>Өөрийн хөрөнгө</b>
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: <b>5.885.000:000 (Таван тэрбум найман зуун наян таван сая) төгрөг</b>
ТШЗ 6.5	Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.
ТШЗ 7.1	Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.
ТШЗ 7.3	Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.
ТШЗ 7.4	ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.
<b>Б. АГУУЛГА</b>	
ТШЗ 9.1	Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.
ТШЗ 9.2	Тодруулга авах хүсэлтийг Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна. Хүлээн авагчийн нэр: <i>Худалдан авах ажиллагааны мэргэжилтэн</i> Хаяг: <b>[Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Дулааны гуравдугаар цахилгаан станц] ТӨХК-ийн байр, 215 тоот.</b> Утасны дугаар: <b>11-344111</b> Цахим шуудангийн хаяг: <b>ps3@tes3.energy.gov.mn</b>



<b>ТШЗ 9.3</b>	Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.
<b>ТШЗ 9.4</b>	Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.
<b>ТШЗ 9.5</b>	Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө.
<b>ТШЗ 10.1</b>	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: <b>“Үгүй”</b>
<b>В. ТЕНДЕР БЭЛТГЭХ</b>	
<b>ТШЗ 12.1</b>	Тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.
<b>ТШЗ.13.1</b>	Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн ажил гүйцэтгэх техникийн болон үнийн санал байна.
<b>ТШЗ.13.2</b>	Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:
<b>ТШЗ.13.2.1</b>	ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;
<b>ТШЗ.13.2.2</b>	Оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/; (Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд дээрх баримт бичгийг консулийн баталгаа эсхүл апостиль гэрчилгээг гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ)
<b>ТШЗ.13.2.4</b>	Оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;
<b>ТШЗ.13.2.5</b>	Тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;
<b>ТШЗ.13.2.6</b>	Санал болгож буй ажил ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;
<b>ТШЗ.13.2.7</b>	ТШЗ-ны 21-д заасан ажлын төсөв;
<b>ТШЗ.13.2.8</b>	ТШЗ-ны 21.7-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;
<b>ТШЗ.13.2.9</b>	Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

<b>ТШЗ.14.1</b>	Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ
<b>ТШЗ 15.1</b>	Хувилбарт санал ирүүлэхийг: <b>“Зөвшөөрөхгүй”</b>
<b>ТШЗ 16.1.2</b>	<p>Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: “Шаардана”</p> <ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу өр төлбөр төлүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байхыг хориглоно, татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер зарласнаас хойших өдрийн байдлаар бүрэн төлсөн байна.</li> <li>- Монгол Улсын хуулийн этгээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт, нийгмийн даатгал, татварын тодорхойлолтыг ирүүлэх шаардлагтай, “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> болон “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын, Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас шалгана.</li> </ul> <p>(Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан тухайн улсын хууль тогтоомжийн дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, татвар, нийгмийн даатгалын хураамж, төлбөрөө төлсөн болохыг нотлох баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гэрчилгээ гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ.)</p> <ul style="list-style-type: none"> <li>- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх шаардлагагүй бөгөөд “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан шалгана.</li> </ul> <p>(Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан дээрх баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гэрчилгээ гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ.)</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тендерт оролцогч нь хуулийн 7.1-д заасан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдлийг баталгаажуулж V бүлгийн Маягт 8-д заасан ерөнхий шаардлагыг хангасан талаарх мэдэгдлийг үнэн зөв мэдүүлж ирүүлнэ.</li> </ul>
<b>ТШЗ 16.1.2</b>	<p>Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ</p> <p>(Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан дээрх баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гэрчилгээ гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ.)</p>
<b>ТШЗ 16.1.2.1</b>	Хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;
<b>ТШЗ 16.1.2.2</b>	Гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

ТШЗ 16.1.2.3	Тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.
ТШЗ 16.4	Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.
ТШЗ 17.3	Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.
ТШЗ 17.4	Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
ТШЗ 17.5	Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.
ТШЗ 18.1	<p>Санхүүгийн чадавхын шаардлага: <b>“Шаардана”</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Борлуулалтын орлогын хэмжээ: Тендерт оролцогчийн 2021, 2022, 2023 онуудын тус бүрийн санхүүгийн тайланд тусгагдсан борлуулалтын орлого нь нийт батлагдсан төсөвт өртгийн 50 хувиас багагүй байх шаардлагатай.</li> <li>2. Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ: Тендерт оролцогчийн түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 50 хувиас багагүй байх шаардлагатай.</li> <li>3. Өр төлбөртэй холбогдох шаардлага: Улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх харилцагч банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байна</li> </ol> <p>(Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан дээрх баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гэрчилгээ гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ.)</p>
ТШЗ 18.2	<p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Борлуулалтын орлогын мэдээллийг тендерт оролцогчийн санхүүгийн тайлангаас шалгах тул сүүлийн 3 жилийн санхүүгийн аудитлагдсан тайланг ирүүлэх шаардлагатай.</li> <li>2. Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээний нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- 2021, 2022, 2023 онуудын санхүүгийн тайланд тусгагдсан түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ</li> <li>- Тендер нээхээс өмнө оролцогчийн харилцагч банкнаас авсан байгууллагын дансны үлдэгдлийн талаарх тодорхойлолт;</li> <li>- Тендерт оролцогч нь төслийн санхүүжилтийг өөрийн хөрөнгөөр бус зээл авч хэрэгжүүлэх тохиолдолд арилжааны банкнаас зээл олгох тухай мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт; (харилцагч банкны мэдэгдэл нь зээл олгох асуудлыг судлан үзэх боломжтой гэх мэт банканд бодитой санхүүгийн үүрэг хүлээгээгүй бол түүнийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.)</li> </ul> </li> </ol>

	<ul style="list-style-type: none"> <li>- Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс тендер шалгаруулалт зарласан өдрөөс хойш авсан, шалгах боломжтой QR код бүхий “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг ирүүлнэ. Уг тодорхойлолтод төлөгдөж дуусаагүй зээлийн мэдээлэл “Хэвийн бус” байгаа тохиолдолд татгалзах үндэслэл болно. (“Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг <a href="http://www.sainscore.mn">www.sainscore.mn</a>, <a href="http://www.burenscore.mn">www.burenscore.mn</a> хаягаар хандан авна. Харилцагч банкны тодорхойлолтыг тендерийг үнэлэхэд харгалзан үзэхгүй.)</li> </ul> <p>(Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан дээрх баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гэрчилгээ гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ.)</p>
<p><b>ТШЗ 19.1</b></p>	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлага: <b>“Шаардана”</b></p> <p>Ажил гүйцэтгэх хүний нөөц: <b>“Шаардана”</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Төслийн удирдагч эсвэл менежер, ерөнхий инженер нь 10-аас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, үүнээс 25 МВт-аас багагүй нэгж блокын хүчин чадалтай дулааны цахилгаан станцын засвар, үйлчилгээний ажилд удирдаж ажилласан туршлагатай байна.</li> </ul> <p>Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: <b>“Шаардана”</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Төслийн ажлыг гүйцэтгэхэд ажлын даалгаварт тусгагдсан шаардлагатай бүх үндсэн тоног төхөөрөмж, багаж, техник хэрэгсэлийг гүйцэтгэгч компани бүрэн төлөвлөж жагсаалт гаргана ирүүлнэ.</li> <li>- Төслийн ажилд ашиглагдах тоног төхөөрөмж, техник хэрэгсэлийн 50 хувь нь өөрийн эзэмшлийн байх ба 50 хувийг нь түрээсийн гэрээ байгуулж болно.</li> </ul> <p>Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: <b>“Шаардана”</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Тендерт оролцогч нь сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг хийж гүйцэтгэсэн байх</li> <li>- 25 мВт болон түүнээс дээш хүчин чадалтай нүүрсээр галладаг дулааны цахилгаан станцын турбины засварын ажлыг гүйцэтгэсэн сүүлийн 3 жилд гүйцэтгэсэн ажлын талаарх туршлагатай байх</li> <li>- 25 мВт болон түүнээс дээш хүчин чадалтай нүүрсээр галладаг дулааны цахилгаан станцын зураг төсөл боловсруулах сүүлийн 3 жилд гүйцэтгэсэн ажлын туршлагатай байх</li> </ul> <p>(Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан дээрх баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гэрчилгээ гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ.)</p> <p>Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: <b>“Шаардана”</b></p>

	<ul style="list-style-type: none"> <li>- Тендерт оролцогч хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээллийг энэ тендерийн баримт бичгийн V бүлгийн Маягт 5-н дагуу мэдээллийг бөглөж, илгээнэ.</li> </ul> <p>(Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан дээрх баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гэрчилгээ гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ.)</p> <p>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: <b>“Шаардана”</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Тендерт оролцогч нь 25 мВт хүртэлх турбин генератор түүний сэлбэг хэрэгслийг үйлдвэрлэгч эсвэл засвар гүйцэтгэх, угсаралтын ажил гүйцэтгэгч компани байх шаардлагатай ба түүнийг нотлох баримтыг ирүүлэх;</li> <li>- Тендерт оролцогч өөрөө үйлдвэрлээгүй барааг санал болгох тохиолдолд уг барааг нийлүүлэх боломжтой болохыг нотлох нийлүүлэгч, үйлдвэрлэгчтэй байгуулсан гэрээ, эсхүл тэдгээрээс энэ тухай гаргасан албан бичиг итгэмжлэл ирүүлэх</li> <li>- Тендерт оролцогч техникийн даалгаварын дагуу нийлүүлэх бараа бүтээгдэхүүний болон угсаралтын зураг төслийг гаргах ба гаргасан зураг төсөл нь зураг төсөл гаргах эрх бүхий мэргэжлийн компанийн гаргасан зураг төсөл байна.</li> <li>- Төслийн техникийн даалгаврын дагуу ажлын төлөвлөгөө, графикийг оновчтой төлөвлөсөн байх.</li> </ul> <p>(Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан дээрх баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гэрчилгээ гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ.)</p>
<p><b>ТШЗ 19.2</b></p>	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Ажил гүйцэтгэх хүний нөөцийн шаардлагыг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- Тендерт оролцогч хүний нөөцийн талаарх мэдээллийг энэ тендерийн баримт бичгийн V бүлгийн Маягт 2-н дагуу мэдээллийг бөглөж ирүүлнэ.</li> <li>- Тендерт оролцогч санал болгож буй ажилтны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, тэдгээрийн туршлагыг багтаасан анкет ирүүлнэ. - МУ-ын иргэний сургууль төгссөн дипломын хуулбарыг ирүүлэх шаардлагагүй. “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллийн сангаас шалгах бөгөөд “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-д инженер, техникийн ажилтнуу дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг тендерт оролцогч лавлах шаардлагатай.</li> <li>- Дээрх мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн бол тендерийн нээлтээс өмнө БШУЯ-ны Мэдээллийн технологи статистикийн хэлтэст хандаж дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгүүлнэ үү.</li> <li>- Дээрх бүртгэл хийгдээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia) системээс мэдээлэл шалгах заавартай дараах холбоосоор танилцана уу.</li> </ul> </li> </ol>

- Хэрэв санал болгож буй ажилтан нь гадаад улсад сургууль төгссөн бол дипломын хуулбарыг баталгаат орчуулгын төвөөр орчуулж, дипломын хуулбарын хамт ирүүлнэ.

(Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд ажиллах хүчний жагсаалтыг ирүүлэхдээ дипломын хуулбар, мэргэшсэн, зөвлөх зэрэгтэй ажилтны хүчин төгөлдөр мэргэжлийн гэрчилгээг консулын баталгаа эсхүл апостиль гэрчилгээ гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ.)

- Гэрээт ажилтнуудын хувьд энэхүү төсөл арга хэмжээнд ажиллуулахаар байгуулсан хөлсөөр ажиллуулах гэрээний хуулбарыг тендерт хавсарган ирүүлнэ.
- Хөлсөөр ажиллуулах гэрээг зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх шаардлагатай бөгөөд гэрээний хугацаа, үнийн дүн болон бусад нөхцөлийг тодорхой тусгасан байна.
- Тухайн ажлын гэрээний гүйцэтгэлд дээрх санал болгосон ажилтнаас өөр ажилтнаар ажил гүйцэтгүүлсэн тохиолдолд илт худал мэдээлэл бүхий тендер гэж үзэн эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах нөхцөл болохыг анхаарна уу.

(Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд ажиллах хүчний жагсаалтыг ирүүлэхдээ дипломын хуулбар, мэргэшсэн, зөвлөх зэрэгтэй ажилтны хүчин төгөлдөр мэргэжлийн гэрчилгээг консулын баталгаа эсхүл апостиль гэрчилгээ гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ.)

2. Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэлийн шаардлагыг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:

- Тендерт оролцогч нь өөрийн эзэмшлийн болон түрээсийн гэрээний дагуу ашиглах машин механизм, тоног төхөөрөмжийн мэдээллийг энэ тендерийн баримт бичгийн V бүлгийн Маягт 3-н дагуу гаргаж ирүүлнэ.
- Машин механизм, тоног төхөөрөмжийн түрээсийн гэрээ нь Иргэний хуулийн 318 дугаар зүйлд нийцсэн, машин механизмын улсын дугаар, ашиглах хугацаа, түрээсийн төлбөр бусад шаардлагатай мэдээллийг тодорхой тусгасан байх шаардлагатай
- Машин механизм, тоног төхөөрөмжүүд нь арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллага болон хувь хүний эзэмшилд байгаа тохиолдолд түрээсийн гэрээнд эзэмшигчийн мэдээллийг заавал тусгасан байх, холбогдох тайлбар, нотолгоог заавал ирүүлнэ.
- Төсөлд ашиглах машин механизм, багаж хэрэгсэл нь фото зураг, гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ. Хуулбар нь тод гаргацтай байна. (Дээрх машин механизмын эзэмшигчийн талаарх мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)-ээр дамжуулан шалгана. Зөрсөн тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.)

(Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан дээрх баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гэрчилгээ гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ.)

3. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагыг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:

- Оролцогчийн туршлагыг харуулах заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний талаар энэ тендерийн баримт бичгийн V бүлгийн Маягт 4, 6-н дагуу бэлтгэсэн мэдээлэл ирүүлнэ.
- Гэрээний үнийн дүн болон хүчин чадлын туршлагад тооцуулах ижил төстэй ажлын дараах мэдээлийг нотлох баримт бичгийг ирүүлнэ. Ирүүлээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно. Үүнд:
  - o Ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар
  - o Ажил хүлээлцсэн акт
  - o Захиалагчийн тодорхойлолт

(Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан дээрх баримт бичигтэй дүйцэхүйц баримтыг консулын баталгаа эсхүл апостиль гэрчилгээ гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ)

4. Техникийн чадавх болон туршлагын талаар заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаж буйг нотлоход шаардлагатай бусад баримт. Үүнд:

- Ажил гүйцэтгэх нарийвчилсан хугацааны график, календарчилсан төлөвлөгөөг баталгаажуулан ирүүлнэ.
- Тендер илгээх маягыг V бүлгийн Маягт 1-ийн дагуу бөглөж, баталгаажуулж ирүүлнэ.
- Оролцогчийн санал болгож буй үнэд дараах зардлыг тооцсон байна. Үүнд:
  - а) Техникийн хяналтын зардал – 2%
  - б) Магадлашгүй ажил – 2%
- Даалгаварт тусгагдаагүй ажлыг нэмэлт нөхцөлөөр гүйцэтгэх тохиолдолд энэ тухай мэдэгдэл ирүүлнэ.
- Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалтыг энэ тендерийн баримт бичгийн V бүлгийн Маягт 7-н дагуу ирүүлнэ
- Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан ажлын даалгавар, техникийн үзүүлэлтийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн ажлыг гүйцэтгэн дуусгаж, ашиглалтад хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.
- Техникийн үзүүлэлтийг харуулсан өгөгдлийн хүснэгтийг бүрэн бөглөж ирүүлээгүй, техникийн ерөнхий шаардлага, нарийвчилсан шаардлагыг тус тус хангаагүй техникийн санал ирүүлсэн тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.
- Гүйцэтгэгч компани нь тоног төхөөрөмжийн үйлдвэрийн баталгааг үйлвэрлэгчээс захиалагчид гаргаж ирүүлнэ.
- Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт (Adobe PDF) шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод байх шаардлагатай бөгөөд уншигдахгүй материалыг ирүүлээгүйд тооцно.
- Нотлох шаардлагатай бусад баримтад тусгасан шалгуур үзүүлэлт, шаардлагаас зөрүүтэй, эсхүл дутуу баримт бичиг ирүүлсэн бол захиалагч тендерээс татгалзах үндэслэл болно.


(Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан дээрх баримт бичигтэй дүйцэхүйц баримтыг консулын баталгаа эсхүл апостиль гэрчилгээ гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ)

<p><b>ТШЗ 19.3</b></p>	<p>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: <b>“Шаардана”</b></p> <p>Тендерт оролцогч компани нь тухайн улсад эсхүл Монгол улсад мөрдөгдөж байгаа холбогдох журмын дагуу доорхи ажлуудыг гүйцэтгэхийг зөвшөөрсөн дүйцэх эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй байна. Тусгай зөвшөөрлийн хуулбарыг эрх бүхий байгууллагаар баталгаажуулан ирүүлнэ.</p> <p>Тусгай зөвшөөрлийн ажил, үйлчилгээний төрөл:</p> <ul style="list-style-type: none"> <li>- ТЗ-4.4 0,07-8,0 МПа /0,7-80,0 кгс/см2/ болон түүнээс дээш даралттай даралтад савны угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ</li> <li>- ТЗ-5.4 0,07-8,0 МПа /0,7-80,0 кгс/см2/ болон түүнээс дээш даралттай дулааны шугам хоолой, дулаан дамжуулах төвийн угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ</li> <li>- ТЗ-7.2 0,07-4,0 МПа /0,7-40,0 кгс/см2/-аас дээш даралтад ажилладаг тоноглолын угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ</li> <li>- Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах</li> <li>- Тендерт оролцогч, түншлэл, туслан гүйцэтгэгч нь гүйцэтгэх үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай бөгөөд тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг Тусгай зөвшөөрлийн цахим мэдээллийн сан (<a href="http://www.license.energy.gov.mn">www.license.energy.gov.mn</a>), Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>) -ээс шалгана.</li> <li>- Тусгай зөвшөөрлийн цахим мэдээллийн сан болон Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем дэх тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл нь үнэн зөв, бүрэн гүйцэт эсэхийг тендерт оролцогч нь нягтлах үүрэгтэйг анхаарна уу.</li> <li>- Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа нь тендерийн хүчинтэй байх хугацаанд хүчин төгөлдөр байна. Хэрэв тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан бол эрх бүхий байгууллагын хугацааг сунгасан тухай шийдвэрийг ирүүлнэ.</li> <li>- Эрчим хүчний эх үүсвэр, дулааны сүлжээ, түүний барилга байгууламжийн барилга угсралтын чиглэлээр бусад байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлүүдийг дүйцүүлэн тооцохгүй.</li> </ul> <p>(Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан дээрх баримт бичигтэй дүйцэхүйц баримтыг консулын баталгаа эсхүл апостиль гэрчилгээ гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ.)</p>
<p><b>ТШЗ 21.61</b></p>	<p>Санал болгож буй ажил нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.</p>
<p><b>ТШЗ 21.6</b></p>	<p>Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: <b>“Тохируулахгүй тогтмол байна”</b></p>
<p><b>ТШЗ 24.1</b></p>	<p>Тендерийн баталгааны дүн: <b>29.425.000 [Хорин есөн сая дөрвөн зуун хорин таван мянган ] төгрөг байна.</b></p>
<p align="center"><b>Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ</b></p>	



ТШЗ 25.5	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 22 дугаар зүйлийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээнэ.</li> <li>- Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг энэ тендерийн баримт бичгийн V бүлгийн Маягт 7-н дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ. Бүх материалыг нууцалж ирүүлсэн тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</li> </ul>
ТШЗ 26.1	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: <b>2025 оны 01-р сарын 20-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>09 цаг 00 минут</b></p>
ТШЗ 26.2	<p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: <b>2025 оны 01-р сарын 20-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>09 цаг 10 минут</b></p>
<b>Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ</b>	
ТШЗ 31.1	Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг: <b>“Үгүй”</b>
ТШЗ 32.1	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: <b>“Үгүй”</b>
<b>Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ</b>	
ТШЗ 37.1	Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: <b>“Тийм”</b> Гүйцэтгэлийн баталгааны дүн нь гэрээний үнийн 3 хувь байна.
<b>Ё. БУСАД</b>	
ТШЗ 38.1	Урьдчилгаа төлбөр олгох эсэх <b>“Үгүй”</b>

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА



БАТЛАВ  
Л.ЭРХБААТАР

ПТ-25-90/10М ТУРБИГЕНЕРАТОР №7-ЫН ЦИЛИНДР СОЛИХ  
АЖЛЫН ДААЛГАВАР

#### 1. ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

“ДЦС-3” ТӨХК-ийн ПТ-25-90/10М маягийн турбогенератор №7-ийн өндөр даралтын цилиндр, дунд даралтын цилиндр, нам даралтын цилиндрүүдийг холбох шпилька, гайк зэрэг дагалдах сэлбэг эд ангийн хамт иж бүрдэлээр үйлдвэрлэх, нийлүүлэх, турбины хуучин бетон суурин дээр цилиндрийг солих ажил юм. Нийлүүлэгдсэн цилиндр болон дагалдах иж бүрдэл нь ЗХУ-ын Калуга хотын турбины үйлдвэрт 1977 онд үйлдвэрлэгдсэн ПТ-25-90/10М маягийн 9143 үйлдвэрийн дугаартай Улаанбаатар хотын ДЦС-3 ТӨХК-ийн өндөр даралтын станцад суурьлуулагдсан турбогенератор №7-ын төмөр бетон суурь, хуучин роторт өөрчлөлтгүй шууд таарах шинэ (2025 онд үйлдвэрлэсэн), үйлдвэрлэгчийн техникийн зураг, техникийн нөхцөлийн дагуу бэлтгэгдэж эцсийн боловсруулалт бүрэн хийгдсэн үйлдвэрлэгчийн чанарын шалгалтын сертификат бүхий байна.

Турбогенератор №7-д цилиндр, дагалдах эд ангиудыг шинээр сольж суурилуулахдаа Монгол улсад мөрдөгдөж байгаа норм, стандарт, дүрмийг мөрдөж гүйцэтгэнэ.

Дээрх ажлын хүрээнд турбиныг задлах, цилиндрийг үйлдвэрлэх, нийлүүлэх, угсарч суурилуулах, турбогенераторыг ажилд оруулан туршиж шалган хүлээлгэж өгөх ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч нь ажлын даалгаварт заагаагүй боловч цилиндрийг суурилуулахад шаардагдах бүх материал, тоног төхөөрөмжийг бэлдэж, ажлыг гүйцэтгэхэд шаардагдах аюулгүй ажиллагаа, техникийн үйлчилгээ, найдвартай ажиллагааг хангахтай холбоотой тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг нийлүүлэх ба тоног төхөөрөмж нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бүх холбогдох дүрэм, стандарт, зааварт нийцсэн байх ёстой.

Ажлын хүрээ нь энэ даалгаварт заасан бүх эд анги, ажлыг багтаасан дараах ажил үйлчилгээг хамрах ёстой. Үүнд:

1. Уурын турбиныг технологийн дагуу бүрэн задлаж буулгалтын ажлыг хийх
2. Техникийн шаардлагад заасны дагуу цилиндрийг угсарч суурилуулах.
3. Цилиндрийг угсарч суурилуулан ажилд залгасны дараа холбогдох норм дүрэм стандартын дагуу баталгаажуулах туршилт, тохируулга хийх.
